

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

КОД: ТӨА-2024/300/НА-СТА- АУДИТЫН ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАЯНХАНГАЙ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2023 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273463. Цахим хаяг: amarjargal@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал: С.Оюунгэрэл
Утас: 99170900 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.26 № 01/76

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Баянхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхангай сумын хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тус байгууллага нь 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, үнэлгээ арга зүй, технологи, суралцагчийн эрх, хамгаалал, хөгжил, төлөвшил, тэгш хамран сургалт, ажил мэргэжлийн баримжаа, багш, ажилтны мэргэжлийн тасралтгүй хөгжил, удирдах ажилтныг мэргэжил арга зүйгээр хангах, зөвлөн туслах олон нийтийг энэ чиглэлийн мэдээллээр хангах, дэмжлэг үзүүлж ажиллах, холбогдох талуудын түншлэлийн үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дүнг нэмэгдүүлэх чиглэлээр төлөвлөн гүйцэтгэлийг ханган ажилласан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

019020085

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг төлөвлөн, 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжүүлж ажилласан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>125,989,473.56</u>	<u>99,305,745.76</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	91,753,949.56	62,424,127.76
312	Банканд байгаа бэлэн мөнгө	91,753,949.56	62,424,127.76
3121	Төгрөг	91,753,949.56	62,424,127.76
31211	Төрийн сангийн харилцах	91,753,949.56	62,424,127.76
35	БАРАА МАТЕРИАЛ	34,235,524.00	36,881,618.00
354	Хангамжийн материал	34,235,524.00	36,881,618.00
35410	Бичиг хэргийн материал	1,159,000.00	208,500.00
35420	Аж ахуйн материал	25,933,184.00	27,044,914.00
35460	Хүнсний материал	4,242,130.00	5,839,250.00
35470	Бусад хангамжийн материал	2,901,210.00	3,788,954.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>150,168,339.14</u>	<u>158,192,730.95</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	150,168,339.14	158,192,730.95
392	Биет хөрөнгө	141,750,339.14	149,774,730.95
39201	Барилга, байгууламж, орон сууц	158,235,582.00	178,235,582.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-31,041,926.10	-39,319,773.06
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	26,002,977.66	25,864,897.66
39206	Хуримтлагдсан элэгдэл	-19,893,844.36	-20,285,994.32
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,457,554.38	21,233,704.38
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,331,337.58	-20,635,018.85
39214	Бусад үндсэн хөрөнгө	37,139,064.00	37,139,064.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-30,160,730.86	-32,800,730.86
39217	Ном	343,000.00	343,000.00
393	Биет бус хөрөнгө	8,418,000.00	8,418,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,418,000.00	8,418,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>276,157,812.70</u>	<u>257,498,476.71</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>573,825.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	573,825.00	00.00
413	Өглөг	573,825.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	529,825.00	00.00
4136	Бусад өглөг	44,000.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	44,000.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>275,583,987.70</u>	<u>257,498,476.71</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	275,583,987.70	257,498,476.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	121,273,620.40	121,273,620.40
51101	Өмч: - төрийн	121,273,620.40	121,273,620.40
512	Хуримтлагдсан үр дүн	138,559,216.56	120,667,865.57
51210	Өмнөх үеийн үр дүн	68,869,976.62	138,753,376.56
51220	Тайлант үеийн үр дүн	69,689,239.94	-18,085,510.99
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	15,751,150.74	15,556,990.74
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>276,157,812.70</u>	<u>257,498,476.71</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	434,572,551.00	368,765,044.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,090,850.00	21,919,744.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,090,850.00	21,919,744.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,090,850.00	21,919,744.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	7,090,850.00	21,919,744.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	427,481,701.00	346,845,300.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	350,319,200.00	294,338,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	350,319,200.00	294,338,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,866,700.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,866,700.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,295,801.00	52,507,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,295,801.00	52,507,300.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	364,883,311.06	386,850,554.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	364,883,311.06	386,850,554.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	344,762,088.64	386,847,928.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,329,080.92	242,837,915.76
210101	Үндсэн цалин	155,467,338.45	181,875,489.05
210102	Нэмэгдэл	45,170,858.08	51,824,163.01
210104	Урамшуулал	8,690,884.39	9,138,263.70
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,969,619.10	30,667,131.04
210201	Тэтгэврийн даатгал	17,845,955.55	21,161,282.41
210202	Тэтгэмжийн даатгал	2,092,899.41	2,494,379.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,667,599.63	1,964,703.39
210204	Ажилгүйдлийн даатгал	392,248.25	445,471.70
210205	Эрүүл мэндийн даатгал	3,970,916.26	4,601,294.39
210206	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/	00.00	00.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,557,734.00	48,504,673.98
210301	Гэрэл, цахилгаан	5,779,134.00	8,453,599.98
210302	Түлш, халаалт	29,578,600.00	39,931,074.00
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	120,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	12,307,210.00	12,887,470.00
210401	Бичиг хэрэг	1,433,000.00	1,424,900.00
210402	Тээвэр, шатахуун	1,643,120.00	880,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,231,090.00	10,581,870.00
2105	Нормативд зардал	31,942,070.00	36,146,130.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	19,800.00
210502	Хоол, хүнс	31,942,070.00	36,126,330.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	405,000.00	385,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	405,000.00	385,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,251,374.62	15,419,608.19
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,566,500.00	2,412,000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,000.00	00.00
210903	үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	26,649,874.62	13,007,608.19
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,121,222.42	2,626.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,763,200.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,076,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,687,100.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	358,022.42	2,626.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	358,022.42	2,626.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>69,689,239.94</u>	<u>-18,085,510.99</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>69,689,239.94</u>	<u>-18,085,510.99</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>427,481,701.00</u>	<u>346,845,300.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	<u>427,481,701.00</u>	<u>346,845,300.00</u>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	350,319,200.00	294,338,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	350,319,200.00	294,338,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,866,700.00	00.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	57,295,801.00	52,507,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	57,295,801.00	52,507,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>335,727,751.44</u>	<u>376,175,121.80</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>335,727,751.44</u>	<u>376,175,121.80</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>315,606,529.02</u>	<u>376,172,495.78</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	209,653,080.92	242,817,445.55
210101	Үндсэн цалин	156,859,884.35	172,259,151.28
210102	Нэмэгдэл	44,546,189.78	61,657,806.81
210104	Урамшуулал	8,247,006.79	8,900,487.46
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,969,619.10	30,687,601.25
210201	Тэтгэврийн даатгал	17,845,955.55	21,181,752.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,092,899.41	2,494,379.15
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,667,599.63	1,964,703.39
210204	Ажилгүйдлийн даатгал	392,248.25	445,471.70
210205	Эрүүл мэндийн даатгал	3,970,916.26	4,601,294.43
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,557,734.00	48,504,673.98
210301	Гэрэл, цахилгаан	5,779,134.00	8,722,670.96
210302	Түлш, халаалт	29,578,600.00	39,662,003.02
210303	Цэвэр, бохир ус	200,000.00	120,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	00.00
210401	Бичиг хэрэг	103,500.00	00.00
2105	Нормативд зардал	29,082,000.00	37,723,450.00
210502	Хоол, хүнс	29,082,000.00	37,723,450.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,070,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	4,070,000.00	4,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	804,100.00	613,000.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	804,100.00	613,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,366,495.00	11,826,325.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,517,000.00	9,987,225.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,849,495.00	1,839,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,121,222.42	2,626.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	19,763,200.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	9,076,100.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	10,687,100.00	00.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	358,022.42	2,626.02
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	358,022.42	2,626.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	91,753,949.56	(29,329,821.80)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	91,753,949.56	(29,329,821.80)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	91,753,949.56
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	91,753,949.56	62,424,127.76

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	121,273,620.40	15,889,170.24	92,169,211.58	229,332,002.22
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	(6,102,571.42)	(6,102,571.42)
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,273,620.40	15,889,170.24	86,066,640.16	223,229,430.80
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	9,349,869.66	9,349,869.66
C08	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	121,273,620.40	15,751,150.74	138,559,216.56	275,583,987.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	194,160.00	194,160.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	121,273,620.40	15,751,150.74	138,753,376.56	275,778,147.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	(194,160.00)	00.00	(194,160.00)
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	(18,085,510.99)	(18,085,510.99)
D09	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	121,273,620.40	15,556,990.74	120,667,865.57	257,498,476.71

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	386,459,300.00	323,667,821.80	84%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	386,459,300.00	323,667,821.80	84%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	386,459,300.00	323,667,821.80	84%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	295,600,200.00	242,817,445.55	82%
210101	Үндсэн цалин	192,260,100.00	172,259,151.28	90%
210102	Нэмэгдэл	95,102,400.00	61,657,806.81	65%
210104	Урамшуулал	8,237,700.00	8,900,487.46	108%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	36,025,600.00	30,687,601.25	85%
210201	Тэтгэврийн даатгал	24,497,300.00	21,181,752.58	86%
210202	Тэтгэмжийн даатгал	2,882,100.00	2,494,379.15	87%
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,305,600.00	1,964,703.39	85%
210204	Ажилгүйдлийн даатгал	576,600.00	445,471.70	77%
210205	Эрүүл мэндийн даатгал	5,764,000.00	4,601,294.43	80%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	613,000.00	613,000.00	100%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	613,000.00	613,000.00	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12907200.00	11826325.00	92%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,068,100.00	9,987,225.00	90%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,839,100.00	1,839,100.00	100%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	294,706,100.00	294,338,000.00	100%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	294,338,000.00	294,338,000.00	100%
131001	Улсын төсвөөс санхүүжих	294,338,000.00	294,338,000.00	100%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	368,100.00	00.00	0%
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	368,100.00	00.00	0%
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	91,753,949.56	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	62,424,127.76	
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01	01	
610001	Төсвийн байгууллага	01	01	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	16	16	
620001	Удирдах ажилтан	01	01	
620002	Гүйцэтгэх ажилтан	08	08	
620003	Үйлчлэх ажилтан	07	07	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 9,391.4 мянган төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 9,391.4 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх 3 албан шаардлага хүргүүлж, 1,404.4 мянган төгрөгийн 3 зөвлөмж хүргүүллээ.

5.2 Албан шаардлага

5.2.1. Байгууллагын 77 нэр төрлийн 85,631.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөс 65 нэрийн төрлийн 54,411.3 мянган төгрөгийн хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн байгаа нь хөрөнгийн бүртгэлийг бодит үнэ цэнээр бүртгэж тайлагнаагүй, тооллого тооцооны үр дүнг хэлэлцээгүй, чанар байдлыг тодорхойлоогүй, ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийн талаарх тодруулга, толилуулга тайлан бэлтгэж тайлагнаагүй байгаа нь санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж тайлагнасан байх гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Аудитад үйл ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл, үр дүнгийн хэрэгжилтийн талаар тайлан, санхүүгийн тодруулга тайлан ирүүлээгүй байгаа нь төсвийн захирагч эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, сум орон нутгийн боловсролын сургалтын байгууллагыг захиргааны болон мэргэжлийн удирдлагаар ханган, хууль тогтоомж, захиргааны шийдвэрийг хэрэгжүүлж, хугацаанд нь тайлагнах, удирдах ажилтны ёс зүй, манлайлал шуурхай байдлыг эрхэмлэн ажиллах гэсэнтэй нийцээгүй.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Мөнгөн хөрөнгийн түүврээр горим сорил хэрэгжүүлэхэд үйл ажиллагааны зардал, бараа түүхий эд, материал худалдан авах анхан шатны цахим баримтын бүрдэлд 7,987.4 мянган төгрөгийн баримт илүү бүртгэгдсэн баримтжуулаагүй, баталгаажуулаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “ холбогдох олон улсын стандарт , эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянан, баталгаажуулах” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, санхүүгийн оршин байх, тохиолдсон байх, үнэлгээ, иж бүрэн байх, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх , төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг үндэслэн өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой

1.1 Илрүүлэлт: Анхан шатны баримтын талаар

Бараа ажил үйлчилгээ, түүхий эд материал худалдан авахдаа гэрээ байгуулаагүй анхан шатны цахим баримтын бүрдэлд 1,404.4 мянган төгрөгийн гүйлгээ дутуу бүртгэгдсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5. "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." заалтуудыг хэрэгжүүлж ажиллах, гэсэнтэй нийцээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим баримтын бүрдэлгүй гүйлгээ гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

5.3.2 Үндсэн хөрөнгийн талаар

1.2 *Илрүүлэлт:* Үндсэн хөрөнгийн ангиллыг үнэн зөв бүртгэж тайлагнаагүй, элэгдэх хугацааг бодитой тодорхойлж бүртгэлд тусгаагүй, санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг зөв ангилж, тодруулж тайлагнасан байх гэсэнтэй нийцээгүй байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх, бүртгэгдэх хэрэгтэй бүх ажил гүйлгээ болон үйл явдлыг бүртгэлд тусгасан, холбогдох тодруулгыг оруулсан байх гэсэнтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн ангиллыг үнэн зөв бүртгэж, тайлагнах

5.3.3 Бичиг хэрэг хөтлөлтийн талаар

1.3 *Илрүүлэлт:* Тус байгууллага нь бичиг хэрэг хөтлөлт, дээд газраас ирсэн бичиг, албан тоотууд, тушаал шийдвэрүүд нь баримт бичиг бүртгэл, хүлээн авах, явуулах журам, архивд шилжүүлэх ажил нь зохион байгуулалтгүй баримт бичгийг боловсруулах, ангилах, баталгаажуулах, хэрэг болгон бүрдүүлэх, ач холбогдлыг нь үнэлэн тогтоогоогүй байгаа нь бичиг хэргийн стандарт, архивын дүрэм журамтай нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Албан хөрөнгө хөтлөлтийн стандартыг мөрдөн ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын хөрөнгө үлдэх өртөггүй анхны өртгөө нөхсөн.	1				1							
Худалдан авалт хийхдээ баримтжуулаагүй	1	1,404.4					1	1,404.4				
Бичиг хэрэг хөтлөлт зохион байгуулалт, эмх цэгцгүй	1						1					
Дүн	3	1,404.4			1		2	1,404.4				

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
	НИЙТ	1	1			1			

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас: +976 70272582, +976 70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn